



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/33

Мөрөн сум

“Шинэ хөдөө” төслийн үйл ажиллагааны
жагсаалт, төсвийн хуваарь батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, 41.2.6, 65.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Шинэ Хөдөө” төслийн хүрээнд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ажлын жагсаалт, төсөвт өртгийг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсорогдог)-т даалгасугай.

3. Төлөвлөгдсөн бараа, ажил, үйлчилгээг үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжилтийг тухай бүр тооцож, хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар)-т тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны
01 дүгээр сарын 28 өдрийн А/33 дугаар
захирамжийн хавсралт

№	Зардлын утга	Нийт үнэ
1	Махны чиглэлийн Сэлэнгэ үүлдрийн тугалтай үнээ авах	100,000,000
2	Герефорд үүлдрийн шүдлэн бух	20,000,000
3	Сэлэнгэ үүлдрийн бяруун бух	347,480,000
4	Зөгийн аж ахуйг дэмжих /бүл худалдаж авах/	100,000,000
5	Инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргах	32,000,000
6	Төмс хүнсний ногоо тариалах иж бүрдэл (Трактор, анжис, роторт сийрүүлэгч, төмс, сонгино, байцаа, хүнсний ногооны үрлэгч, хураагч, бордоо, бууц цацагч)	380,000,000
7	Усалгааны систем	150,000,000
8	Хадлангийн нөөц бүрдүүлэх, ногоон тэжээл тариалах иж бүрдэл (Трактор, Сэлк, Хадуур, Тармуур, Преслэгч, Хавагч, хор цацагч)	1,610,000,000
9	Арьс шир боловсруулах тоног, төхөөрөмж (Иж бүрэн)	137,500,000
10	Хүлэмж /4*8/	85,500,000
11	Хүлэмж /8*20/	322,500,000
12	Талх, нарийн боовны тоног төхөөрөмж	83,000,000
13	Цагаан идээ боловсруулах тоног төхөөрөмж худалдан авах	12,000,000
14	Малын зохиомол хээлтүүлгийн пункт	45,000,000
15	Малын тэжээлийн үйлдвэр (бага оврын)	60,000,000
16	Компьютер, принтер, тавилга	15,000,000
	НИЙТ	3,499,980,000.00

-----"oOo"-----